



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023-02-24 № 161

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ХАНБОГД СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН  
ШҮҮХЭД**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд 2022 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр мөнгөн хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Ц. ӨСӨХБАЯР

D/Явсан Бичиг/2023он/2023-02-24.Doc

**016030078**



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.02.24

№

131

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ханбогд сум дахь сум дундын шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ханбогд сум дахь сум дундын шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Иргэд, олон нийтэд хууль сурталчлан таниулах болон гэр бүл хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх олон нийтийн сургалт сурталчилгааны ажилд 18.0 сая төгрөгийн зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны тушаалаар 27.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 71.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн данснаас хассан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторовын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

016020246

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ханбогд сумын сум дундын шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2023/36/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.Umnugovi@audit.mn](http://www.Umnugovi@audit.mn)

Өмнөговь аймаг  
Даланзадгад сум  
2023 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: [usukhbayarts@audit.gov.mn](mailto:usukhbayarts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: [Khongorzult@audit.gov.mn](mailto:Khongorzult@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Ж.Болормаа  
Утас: 70533552 Цахим хаяг: [Bolormaaja@audit.gov.mn](mailto:bolormaaja@audit.gov.mn)  
Аудитор: Т.Будсүрэн  
Утас: 70533552 Цахим хаяг: [budsurent@audit.gov.mn](mailto:budsurent@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	1
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	12
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. Аудитын илрүүлэлт.....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.02.24 № 131

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ханбогд сум дахь сум дундын шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ханбогд сум дахь сум дундын шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Иргэд, олон нийтэд хууль сурталчлан таниулах болон гэр бүл хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх олон нийтийн сургалт сурталчилгааны ажилд 18.0 сая төгрөгийн зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны тушаалаар 27.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 71.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн данснаас хассан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

016020246

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,879,528.00</u></b>	<b><u>2,771,898.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	1,000,000.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	1,000,000.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	1,000,000.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	1,000,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,879,528.00	1,771,898.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	1,879,528.00	1,771,898.00
35410	Бичиг хэргийн материал	263,500.00	00.00
35420	Аж ахуйн материал	1,616,028.00	1,771,898.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>295,692,297.91</u></b>	<b><u>271,266,926.49</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	295,692,297.91	271,266,926.49
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	257,514,797.91	232,938,176.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	107,929,520.00	107,929,520.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-4,625,550.72	-6,167,400.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	92,400,000.00	86,320,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-20,833,333.37	-19,553,333.31
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	105,697,145.80	81,724,302.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-43,705,497.30	-36,152,473.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,735,520.00	41,331,520.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30,636,386.50	-34,619,838.13
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,350,000.00	12,350,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-617,499.96
39217	Ном	203,380.00	393,380.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	38,177,500.00	38,328,750.00
39301	Програм хангамж	830,000.00	330,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-692,500.00	-41,250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	38,040,000.00	38,040,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>297,571,825.91</u></b>	<b><u>274,038,824.49</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>297,571,825.91</u></b>	<b><u>274,038,824.49</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	297,571,825.91	274,038,824.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	38,040,000.00	38,040,000.00
51101	Өмч: - төрийн	38,040,000.00	38,040,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	259,531,825.91	235,998,824.49
51210	Өмнөх үеийн үр дүн	259,531,825.91	259,531,825.91
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-23,533,001.42
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>297,571,825.91</u></b>	<b><u>274,038,824.49</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>529,783,437.00</b>	<b>622,528,979.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>94,275,237.00</b>	<b>44,199,379.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	94,275,237.00	44,199,379.00
120009	Бусад орлого	12,080,694.00	35,069,129.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгө	81,891,615.00	6,415,560.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал	302,928.00	2,714,690.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>435,508,200.00</b>	<b>578,329,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	435,508,200.00	560,329,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	435,508,200.00	560,329,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	18,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	18,000,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>478,289,916.49</b>	<b>646,061,980.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>478,289,916.49</b>	<b>646,061,980.42</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	462,004,527.49	589,298,020.42
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	274,682,497.00	365,573,112.00
210101	Үндсэн цалин	229,128,788.00	270,168,169.00
210102	Нэмэгдэл	22,790,818.00	65,742,790.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,658,776.00	10,068,000.00
210104	Урамшуулал	11,104,115.00	19,594,153.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	37,359,201.00	46,898,079.00
210201	Тэтгэврийн даатгал	26,103,281.94	32,244,923.72
210202	Тэтгэмжийн даатгал	2,947,701.28	3,793,519.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,240,581.01	2,910,495.31
210204	Ажилгүйдлийн даатгал	551,585.17	722,648.91
210205	Эрүүл мэндийн даатгал	5,516,051.60	7,226,491.93
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,686,223.00	14,404,961.00
210301	Гэрэл, цахилгаан	2,670,793.00	2,727,651.00
210302	Түлш, халаалт	10,206,350.00	10,206,350.00
210303	Цэвэр, бохир ус	809,080.00	1,470,960.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	38,766,440.00	55,167,443.00
210401	Бичиг хэрэг	9,520,000.00	13,563,145.00
210402	Тээвэр, шатахуун	12,775,835.00	10,960,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,877,405.00	10,572,378.00
210404	Ном, хэвлэл	00.00	597,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	600,000.00	598,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,993,200.00	18,876,920.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	500,000.00	176,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	176,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	36,999,010.00	11,499,900.00
210604	Урсгал засвар	36,999,010.00	11,499,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,984,000.00	4,308,000.00
210702	Дотоод албан томилолт	3,984,000.00	4,308,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,144,275.00	4,860,465.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,020,500.00	2,798,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	641,775.00	1,753,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	76,380.00	128,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	00.00
210807	Газрын төлбөр	114,120.00	114,120.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	52,882,881.49	86,410,060.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	18,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,882,881.49	68,410,060.42
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	16,285,389.00	56,763,960.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	975,400.00	8,221,773.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	7,221,773.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	975,400.00	1,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	15,309,989.00	48,542,187.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,309,989.00	48,542,187.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>51,493,520.51</b>	<b>-23,533,001.42</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>51,493,520.51</b>	<b>-23,533,001.42</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>435,508,200.00</b>	<b>579,329,600.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>1,000,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	1,000,000.00
120009	Бусад орлого	00.00	1,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>435,508,200.00</b>	<b>578,329,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	435,508,200.00	560,329,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	435,508,200.00	560,329,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	18,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	18,000,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>424,008,200.00</b>	<b>575,829,600.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>424,008,200.00</b>	<b>575,829,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>407,722,811.00</b>	<b>519,065,640.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	274,682,497.00	365,573,112.00
210101	Үндсэн цалин	229,128,788.00	270,168,169.00
210102	Нэмэгдэл	22,790,818.00	65,742,790.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,658,776.00	10,068,000.00
210104	Урамшуулал	11,104,115.00	19,594,153.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	37,359,201.00	46,898,079.00
210201	Тэтгэврийн даатгал	26,103,281.94	32,244,923.72
210202	Тэтгэмжийн даатгал	2,947,701.28	3,793,519.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,240,581.01	2,910,495.31

210204	Ажилгүйдлийн даатгал	551,585.17	722,648.91
210205	Эрүүл мэндийн даатгал	5,516,051.60	7,226,491.93
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,686,223.00</b>	<b>14,404,961.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,670,793.00	2,727,651.00
210302	Түлш, халаалт	10,206,350.00	10,206,350.00
210303	Цэвэр, бохир ус	809,080.00	1,470,960.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>37,367,605.00</b>	<b>52,025,123.00</b>
210401	Бичиг хэрэг	9,783,500.00	13,299,645.00
210402	Тээвэр, шатахуун	11,217,000.00	10,960,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,877,405.00	10,572,378.00
210404	Ном, хэвлэл	00.00	597,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	598,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,889,700.00	15,998,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>500,000.00</b>	<b>496,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	496,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>36,999,010.00</b>	<b>11,499,900.00</b>
210604	Урсгал засвар	36,999,010.00	11,499,900.00
<b>2107</b>	<b>омилолт, зочны зардал</b>	<b>3,984,000.00</b>	<b>4,308,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,984,000.00	4,308,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,144,275.00</b>	<b>4,860,465.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,020,500.00	2,798,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	641,775.00	1,753,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	76,380.00	128,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	00.00
210807	Газрын төлбөр	114,120.00	114,120.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>00.00</b>	<b>19,000,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	19,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,285,389.00</b>	<b>56,763,960.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>975,400.00</b>	<b>8,221,773.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	7,221,773.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	975,400.00	1,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>15,309,989.00</b>	<b>48,542,187.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,309,989.00	48,542,187.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>11,500,000.00</b>	<b>3,500,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>11,500,000.00</b>	<b>2,500,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,500,000.00</b>	<b>2,500,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>11,500,000.00</b>	<b>2,500,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,500,000.00	2,500,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-11,500,000.00</b>	<b>-2,500,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>1,000,000.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>1,000,000.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,040,000.00		208,038,305.40	246,078,305.40
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,040,000.00		208,038,305.40	246,078,305.40
C07	Тайлант үеийн үр дүн			51,493,520.51	51,493,520.51
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,040,000.00		259,531,825.91	297,571,825.91
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	38,040,000.00		259,531,825.91	297,571,825.91
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,040,000.00		259,531,825.91	297,571,825.91
D08	Тайлант үеийн үр дүн			23,533,001.42	23,533,001.42
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,040,000.00		235,998,824.49	274,038,824.49

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	561,829,600.00	511,787,413.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	561,829,600.00	511,787,413.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	551,924,900.00	503,565,640.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	407,131,700.00	365,573,112.00
210101	Үндсэн цалин	310,452,000.00	270,168,169.00
210102	Нэмэгдэл	69,598,500.00	65,742,790.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,338,000.00	10,068,000.00
210104	Урамшуулал	13,743,200.00	19,594,153.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,891,500.00	46,898,079.00
210201	Тэтгэврийн даатгал	34,606,200.00	32,244,923.72
210202	Тэтгэмжийн даатгал	4,071,300.00	3,793,519.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,257,100.00	2,910,495.31
210204	Ажилгүйдлийн даатгал	814,300.00	722,648.91
210205	Эрүүл мэндийн даатгал	8,142,600.00	7,226,491.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,600,000.00	14,404,961.00
210301	Гэрэл, цахилгаан	2,800,000.00	2,727,651.00
210302	Түлш, халаалт	12,000,000.00	10,206,350.00
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,470,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,040,600.00	52,025,123.00
210401	Бичиг хэрэг	13,300,000.00	13,299,645.00
210402	Тээвэр, шатахуун	10,962,600.00	10,960,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,578,000.00	10,572,378.00
210404	Ном, хэвлэл	600,000.00	597,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	598,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,000,000.00	15,998,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>500,000.00</b>	<b>496,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	496,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,000,000.00</b>	<b>13,999,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	11,500,000.00	11,499,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,334,600.00</b>	<b>4,308,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,334,600.00	4,308,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,426,500.00</b>	<b>4,860,465.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,281,400.00	2,798,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,779,400.00	1,753,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,600.00	128,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,900.00	66,000.00
210807	Газрын төлбөр	114,200.00	114,120.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1000000.00</b>	<b>1000000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,000,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,904,700.00</b>	<b>8,221,773.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,404,700.00	7,221,773.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	1,000,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>561,829,600.00</b>	<b>511,787,413.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>561,829,600.00</b>	<b>511,787,413.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	561,829,600.00	511,787,413.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>1,000,000.00</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>18,000,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>18,000,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>18,000,000.00</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	<b>18,000,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		18,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	<b>18,000,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>18,000,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		18,000,000.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх нь Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх, мэргэшсэн, тогтвортой, шударга, хариуцлага хүлээдэг байх иргэдэд хүргэх, шударга ёсны үйлчилгээг сайжруулж, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх болон иргэний эрх зүйн ухамсар соёлыг дээшлүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ. Шударга ёс хүний эрх чөлөөний баталгаа байж шударгаар шүүх нь шүүхийн эрхэм зорилго мөн.

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах;
- Шүүхийн хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд хяналт тавих;
- Шүүхэд ирүүлсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх;
- Шүүхийн бичиг хэрэг, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг зохион байгуулах;
- Шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээг авах;
- Хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх, холбогдох шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Тухайн шүүхийн шүүн таслах болон бусад ажиллагааны тоон мэдээлэл гаргах;
- Иргэн, хуулийн этгээдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу шийдвэрлэж, хариу өгөх, хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлдэг.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан. Өмнөговь аймгийн Ханбогд сумын сум дундын шүүхийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийлүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн дотоод журам

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар

ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн/нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23.5 сая төгрөгөөр буюу 8.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	1,000.0	1,000.0
Бараа материал	1,879.5	1,771.8	-107.6
Үндсэн хөрөнгө	396,185.5	368,418.7	-27,766.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>297,571.8</b>	<b>274,038.8</b>	<b>-23,533.0</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	38,040.0	38,040.0	0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>297,571.8</b>	<b>274,038.8</b>	<b>-23,533.0</b>

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгийн дансанд 1.0 сая төгрөг байгаа нь ахмадын сангийн дансны үлдэгдэл, бараа материал, үндсэн хөрөнгө өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан Бараа материалын дансны үлдэгдэл 0.1 сая төгрөгөөр буурсан өмнөх оны нөөцөөс зарцуулсан байна. Үндсэн хөрөнгө 27.7 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийг данснаас хасаж акталсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 561.8 сая, нийт зарлагыг 511.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт төлөвлөсөн төсвийн зардлыг баталж өгсөн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 561.8 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 561.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 511.7 сая төгрөг буюу 91.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 48.5 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	407,131.7	365,573.1	41,558.5	91.1
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,891.5	46,898.0	3,993.4	92.2
3	Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал	16,600.0	14,404.9	2,195.0	86.8
4	Хангамж, бараа материалын зардал	52,040.6	52,025.1	15.4	100
5	Норматив зардал	500.0	496.0	4.0	99.2
6	Эд хогшил, урсгал засварын зардал	14,000.0	13,999.9		100
7	Томилолт, зочны зардал	4,334.6	4,308.0	26.6	99.4
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,426.5	4,860.4	566.0	89.6
9	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000.0	1,000.0		100
10	Урсгал шилжүүлэг	9,904.7	8,221.7	1,682.9	83

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Ханбогд сумын иргэдийн Төлөөлөгчийн Хурлаас 3.0 сая төгрөг, Өмнөговь аймгийн Засаг даргаас 15.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус авч, иргэд, олон нийтэд хууль сурталчлан таниулах болон гэр бүл хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх олон нийтийн сургалт сурталчилгааны ажилд 18.0 сая төгрөгийн зарцуулсан байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Т.Будсүрэн гүйцэтгэж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Ж.Болормаа, чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 478.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.7 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлыг санхүүжүүлээгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг буруу мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-д заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг үнэн зөв тусгаж байх зөвлөмж өгсөн.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн Тамгын газар нь бусад хууль тогтоомжийн хүрээнд санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх асуудал байхгүй байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөговь аймаг дахь Ханбогд сум дахь сум дундын шүүхийн газар нь завсрын аудитаар зөвлөмжийн 7 заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар Өмнөговь аймаг дахь Ханбогд сум дахь сум дундын шүүхийн цалингийн зардал, ажилчдын ээлжийн амралтын тооцооны тулгалт, цалингийн түүврээр илрүүлсэн илрүүлэлт, ур чадварын нэмэгдэл, бичиг хэргийн зардал, шатахууны зардал, тэтгэвэрт гарахад олгосон тэтгэмжийн тооцооны тулгалтуудад горим сорил хэрэгжүүлэн 7 зөвлөмжийн заалтыг асуудлын бүртгэлд тусгасан. Асуудлын бүртгэлээр өгсөн зөвлөмжийн биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үр дүнг аудитын тайланд тусгасан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 104.9 сая төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	104.9	1	104.9	100
Нийт дүн	1	104.9	1	104.9	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0 сая төгрөгийн алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

### 5.1 Төлбөрийн акт:

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага тогтоогдоогүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг буруу мэдээлэхгүй байх.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-д заасантай нийцэхгүй байгаа нь дотоод хяналтын чанар сайжрахгүй байгаа үр дагавартай байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг үнэн зөв тусгаж байх зөвлөмж өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	1	0					1	0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>					<b>1</b>	<b>0</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Байхгүй.								
Дүн								
Нийт дүн	0	0						